

14 хоногийн шуурхай мэдээ

2020 оны Орон нутгийн хөгжлийн сангийн ажилд Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ (ЖГҮ) хийгдлээ.

А.Ууганбаяр ахлагчтай “ХАМТЫН ХҮЧ” иргэний бүлэг нь Смарт худгийн хамгаалалтын хашаа, Худгийн дэргэдэх ногоон байгууламжийн хашааг хугацаанд нь хийж 100 хувийн гүйцэтгэлтэйгээр 2021.08.13-нд ажлын хэсэг томилогдон хүлээж авлаа.

Орон нутгийн хөгжлийн сангаар 2021 онд хийгдэх Ажирхай, Хонгор, Морьт багуудад худаг гаргах ажлын гүйцэтгэл 90%-тай явж байна.

Засаг даргын Тамгын газрын няравын ажлын байр зарлан 2021 оны 08 дугаар сарын 25-нд Б.Алтансүх томилогдон ажиллаж байна.

Газрын алба

Бэлчээрийн төлөв байдал чанарыг фото мониторингийн аргаар судлах ажлыг 2021 оны 08 дугаар сарын 19, 20 ны өдрүүдэд Говь-Угтаал суман дээр байх 12 цэг, мөн хөдөөгийн 3 баг дээр очиж бэлчээр ургамалын ургацын судалгааг хийсэн.

Хөдөлмөр халамж үйлчилгээ

Говь-Угтаал сумын Амьжиргааг дэмжих зөвлөл нь 2021.08.11-ны өдрийн хурлаар ахмад настны асаргааны 3-н хүсэлт, Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн 3-н хүсэлт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны сунгалт, нийт 8-н хүсэлтийг шийдвэрлэн, 2021.08.24-ны хуралдаанаар нийт 7-н асуудлыг шийдвэрлэж Ахмад настны амрах эрхийн бичгийг 3-н хүнд олгож ажиллаа.

8 сарын хүнсний эрхийн бичгийн олголт хийгдэж дууссан.

Мал эмнэлгийн тасаг

Бруцеллёзын өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакциныг 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Хонгор, Морьт, Ажирхай багийн нийт 164 тугал, 9915 хурга, 3983 ишигт тариад байна

Хүүхдийн цэцэрэг

Багш, ажилчид цэцэрлэгийн анги танхим, дотоод цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж байна мөн байгууллагын гал тогооны өрөөний шалыг шинээр плетадаж дуусгалаа.

Бүлгийн багш нар тойргийн хүүхдийн судалгааг нарийвчилан гаргалаа .

7 хоногт 2 удаа гадна талбайн модыг туслах багш ,ажилчид тогтмол услаж байна .

2021 оны 08 дугаар сарын 24-25нд БМДИ-ээс зохин байгуулсан “Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх арилгахад дэмжлэг үзүүлэх сургалт”-нд 4 багш , эрхлэгч, аргазүйч нар хамрагдлаа .

Эрүүл мэндийн төв

Голомтонд 325 м2, урьдчилан сэргийлж 158 м2 нийт 483 м2 газарт ариутгал халдваргүйжүүлэлт хийгдлээ.

Улаанбаатар хотоос ирсэн болон ойрын хавьтлын 61 хүнд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийн Коронавируст халдвараар 3 иргэн батлагдсныг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж эдгээж гаргалаа.

12-17 насны хүүхэд, жирэмсэн, архаг хууч өвчтэй иргэний 1 ба 2 тунгийн вакциныг 13 хүнд, 2 сараас 2 настай 7 хүүхдэд товлोलт вакциныг тус тус хийлээ.

Соёлын төв

Ардын билэг авьяастан М.Буяндэлгэр агсаны хэлсэн егөө үг, зан үйлийг алдаршуулах, өвлөн уламжлуулах зорилгоор “Өв-Эрдэнэ” уралдааныг зарлаж 1-р байр Г.Нямзав 2-р байр Д.Лхамсүрэн, 3-р байр Э.Мишигдорж нар тус тус байруудыг эзэлж шагналыг гардуулан өглөө.

ТАЙЛАН БИЧСЭН

АРХИВ,БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Г.АМАРБАЯР

ХЯНАСАН

ЗДТГАЗРЫН ДАРГА

Н.ӨЛЗИЙТОГТОХ

